



УВС АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/13

Улаангом.

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан тушаалтнуудын ажлын ачааллыг жигдрүүлж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Баяраа-Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Гишүүдэд: З.Ганболд –Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Б.Ядамсүрэн – Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Ч.Энхбаяр –Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Г.Батмөнх- Хууль зүйн хэлтсийн дарга

А.Ариунтуяа –Хүний нөөцийн мэргэжилтэн

Хоёр. Монгол улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2015 оны А/78 дугаар захирамжаар баталсан Тамгын газрын бүтцэд тусгасан албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтыг зааврын дагуу боловсруулан танилцуулж, батлуулан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Баяраа/-д даалгасугай.

ДАРГА  Г.БОЛОР-ЭРДЭНЭ

